



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/01

Улаанбаатар хот

2024 оныг “Бүтээмж-Хамтын ажиллагааг
дээшлүүлэх жил” болгон зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Нийслэл, дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, бүх шатанд бүтээмж, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор дүүргийн хэмжээнд 2024 оныг “Бүтээмж-Хамтын ажиллагааг дээшлүүлэх жил” болгон зарласугай.


2.Зорилтот жилийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг шуурхай зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3.Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд аж аж ахуйн нэгж, байгууллага, хувийн хэвшил, иргэдийн саналыг тусган боловсруулж, Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахыг Ажлын хэсэг (Б.Болормаа)-т үүрэг болгосугай.

4.Зорилтот жилийн хүрээнд зохион байгуулах арга хэмжээг байгууллага, нэгж бүр гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган, иргэд, албан хаагчдын бүтээмжийг дээшлүүлэх, чиглэлээр үр дүнд чиглэсэн ажил зохион байгуулах, салбар дундын уялдаа холбоог сайжруулах, бүх шатанд хамтын ажиллагааг бэхжүүлэхэд анхаарч ажиллахыг Аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

5.Зорилтот жилийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар ханган, явц үр дүнг хагас жил, жилийн эцсийн байдлаар дүгнэн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж, үйл ажиллагааны талаарх мэдээллийг иргэд, олон нийтэд тогтмол хүргэн, сурталчилж ажиллахыг Ажлын хэсэг (Б.Болормаа)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

AJIL\2024 он ажил\захирамж

11230000-25

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны ...⁰¹... дүгээр сарын ...⁰²... ны өдрийн
^{01/01}... дугаар захирамжийн хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Гишүүд:

Засаг даргын Тамгын газрын дарга
Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга
бөгөөд Ажлын албаны дарга (зөвшилцсөнөөр)
Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга
Цэргийн штабын дарга
1 дүгээр хорооны Засаг дарга
2 дугаар хорооны Засаг дарга
Дотоод аудитын албаны дарга
Худалдан авах ажиллагааны албаны дарга
Газар зохион байгуулалтын албаны дарга
Боловсролын хэлтсийн дарга
Нийгмийн даатгалын газрын дарга
Татварын хэлтсийн дарга
Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга
Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн дарга
Онцгой байдлын хэлтсийн дарга
Цагдаагийн хэлтсийн дарга
Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвийн захирал
Биеийн тамир, спортын хорооны дарга
Эрүүл мэндийн төвийн дарга
Соёлын ордны захирал
"Хангай" цогцолбор сургуулийн захирал
44 дугаар цэцэрлэгийн эрхлэгч
207 дугаар цэцэрлэгийн эрхлэгч
"Илч-Орд" ОНӨААТҮГ-ын захирал
Ус суваг ашиглалтын товчооны дарга
Багахангайн үйлдвэрлэл технологийн парк УТҮГ-ын дарга
Багахангайн тохижилт ОНӨААТҮГ-ын захирал
Баганхангайн гэрэлтүүлэг ОНӨААТҮГ-ын захирал
Мал эмнэлгийн тасгийн дарга
Багахангай өртөөний дарга

Нарийн бичгийн
дарга

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга